



GRATA
INTERNATIONAL

ТӨЛӨӨНИЙ ГАЗРЫН БҮРТГЭЛИЙН ПРОЦЕСС

www.gratanet.com

ТӨЛӨӨНИЙ ГАЗАР

“Төлөөний газар” –г Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйл, Монгол Улсаас гадаад улстай байгуулсан “Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын хэлэлцээр” –ийн 5, 7 дугаар зүйлд тус тус тодорхойлсон. Товчоор хэлбэл, Монгол улсад албан татвар төлөгчийн үйл ажиллагааг бүрэн болон хэсэгчлэн явуулж байгаа нэгжийг ТӨЛӨӨНИЙ ГАЗАР гэнэ.

Хамрах хүрээ:

Төлөөний газарт дараах нэгжийг хамруулна. Үүнд:

- Аж ахуйг удирдан явуулдаг газар;
- Салбар, тасаг;
- Сургалт, семинар явуулдаг, үзэсгэлэн худалдаа эрхэлдэг газар;
- Агуулах, худалдаа үйлчилгээний газар;
- Уурхай, гарзын тос буюу байгалийн хийн цооног, уурхай буюу ашигт малтмал олборлодог газар;
- Үйлдвэр;
- бусад газар, нэгж, байр.

Түүнчлэн дараах нэгж, этгээд, үйл ажиллагааг төлөөний газарт тооцно:

1

Үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 90 ба түүнээс дээш хоногийн хугацаанд үргэлжлэх барилгын талбай, барилга байгууламж, угсралт буюу суурилуулалтын объект, тэдгээртэй холбоотой барилгын болон хяналтын үйл ажиллагаа эрхлэх нэгж;

2

Үргэлжилсэн 12 сарын хугацаанд нийт 183 ба түүнээс дээш хоног өөрийн ажиллагчид болон өөр бусад хөлсний ажилтнаар Монгол улсад байрладаг албан татвар төлөгчид техникийн, зөвлөхийн, удирдлагын, хяналтын болон бусад үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа;

3

Монгол улсад байрладаггүй албан татвар төлөгчийн нэрийн өмнөөс дараах үйл ажиллагаа явуулдаг этгээдийг төлөөний газарт тооцно:

- а) бараа бүтээгдэхүүнийг хадгалдаг, борлуулдаг, нийлүүлдэг;
- б) биечлэн гэрээ байгуулдаг, эсхүл Монгол улсад байрладаггүй албан татвар төлөгчийн гэрээний гол нөхцөлийг өөрчлөхгүйгээр тухайн гэрээ байгуулах ажлыг удирдан зохион байгуулдаг. Гэрээ нь дараах шинжийн аль нэгийг агуулсан байна:

- i. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн нэрээр байгуулагдах;
- ii. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн өмчилдөг, эсхүл өмчилдөггүй боловч ашиглах, эзэмших эрхтэй хөрөнгийг шилжүүлэх, эсхүл тухайн хөрөнгийг ашиглах, эзэмших эрхийг бусдад шилжүүлэх;
- iii. Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн үйлчилгээг үзүүлэх.

Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгч нь бусад этгээдээр дамжуулан Монгол Улсад давхар даатгалаас бусад хэлбэрийн даатгалын хураамж авдаг буюу эрсдэлийн даатгал хийдэг бол түүнийг Монгол Улсад төлөөний газартай гэж үзнэ.

Монгол Улсын Их Хурлаас соёрхон баталж, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай олон улсын хэлэлцээр (“Давхар татварын гэрээ”) –т “Төлөөлөгчийн газар” гэснийг төлөөний газартай адилтгаж үздэг. Одоогоор 26 улстай байгуулсан давхар татварын гэрээ хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бөгөөд төлөөний газартай болсонд тооцох хугацаа зэргийг ялгаатай тогтоосон байдаг.

Давхар татварын гэрээнд тусгаснаар дараах үйл ажиллагааг төлөөний газарт тооцохгүй:

- 1 байгууламжийг зөвхөн барааг үзүүлэх, хүргэх зорилгоор ашиглах эсвэл тухайн аж ахуйн нэгжид хамаарах бараа хадгалах;
- 2 аж ахуйн нэгжид хамаарах бараа, бүтээгдэхүүний нөөцийг үзүүлэх, хүргэх зорилгоор хадгалах;
- 3 аж ахуйн нэгжид хамаарах бараа, бүтээгдэхүүний нөөцийг өөр аж ахуйн нэгжээр боловсруулах зорилгоор хадгалах;
- 4 зөвхөн бараа, бүтээгдэхүүн олж авах, аж ахуйн нэгжийн мэдээлэл цуглуулах зорилгоор байгууламжийг хадгалах;
- 5 байгууламжийг зөвхөн аж ахуйн нэгжид бэлтгэх болон туслах шинж чанартай бусад үйл ажиллагаа явуулах зорилгоор хадгалах;
- 6 байнгын аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь бэлтгэл болон туслах шинж чанартай байх ба дээр дурьдсан аливаа үйл ажиллагааг хослуулах зорилгоор үйл ажиллагаа явуулах.

Иргэн аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж, тухайн аж ахуйн нэгжийн нэрийн өмнөөс гэрээ байгуулах эрх мэдэлтэй ба үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлдэг бол тухайн аж ахуйн нэгж нь тухайн улсын нутаг дэвсгэрт төлөөний газартай гэж үзнэ. Хэрэв тухайн этгээдийн үйл ажиллагаа дээр заасан үйл ажиллагаагаар хязгаарлагдахаас бусад тохиолдолд тухайн аж ахуйн нэгж байнгын үйл ажиллагаа эрхэлдэг газраар дамжуулан үйл ажиллагаа эрхэлж байгаа тохиолдолд тухайн байнгын үйл ажиллагаа явуулж буй газрыг төлөөний газарт тооцохгүй.

Брокер, ерөнхий комиссар эсвэл бие даасан бусад төлөөлөгчөөр дамжуулан тухайн улсад үйл ажиллагаа явуулдаг тохиолдолд аж ахуйн нэгжийг тухайн улсад байнгын төлөөлөгчийн газартай гэж үзэхгүй.

Хэлэлцэн тохирогч улсын оршин суугч аж ахуйн нэгж нь Хэлэлцэн тохирогч нөгөө Улсын оршин суугч аж ахуйн нэгжийг хянадаг, эсхүл нөгөө улсад тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг (төлөөний газраар дамжуулан эсвэл өөр хэлбэрээр) явуулдаг бол аль нэг аж ахуйн нэгж нь нөгөө аж ахуйн нэгжийн төлөөний газарт тооцогдохгүй.

ТӨЛӨӨНИЙ ГАЗРЫГ АЛБАН ТАТВАР ТӨЛӨГЧӨӨР БҮРТГҮҮЛЭХ

Төлөөний газар нь хуулийн этгээдийн эрхгүй тул хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэхгүй. Харин Монгол улсаас эх үүсвэртэй орлогод татвар ногдуулах зорилгоор төлөөний газрын шаардлага хангасан этгээдийг татвар төлөгчөөр бүртгэж, татвар төлөгчийн дугаар олгож байна.

Төлөөний газрыг албан татвар төлөгчөөр бүртгэх, бүртгэлээс хасах, албан татвар төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн Татварын Ерөнхий Газрын даргын А/272 тоот тушаалаар баталсан “Төлөөний газрыг бүртгэх, бүртгэлээс хасах, албан татвар төлөх, тайлагнах журам” –н дагуу зохицуулжээ.

Татвар төлөгчөөр бүртгүүлэх хугацаа:

Монгол улсаас эх үүсвэртэй орлого олж байгаа Монгол улсад байрладаггүй этгээд нь Монгол улсад төлөөний газрын шаардлага хангасан буюу төлөөний газартай эсэхийг тогтооход холбогдох баримт бичиг, бодит байдлыг харгалзан үзэж,

i) үйл ажиллагаа явуулж эхэлсэн эсвэл ii) гэрээ байгуулсан хугацааны

аль түрүүлж хийгдсэн өдрөөр төлөөний газартай болсон гэж үзнэ.

Уг журмын дагуу, төлөөний газрын шаардлага хангасан этгээд нь үйл ажиллагаа явуулж эхлэхээс ажлын 10 хоногийн өмнө шаардлагатай материалыг бүрдүүлж, татвар төлөгчөөр бүртгүүлэх хүсэлтээ цахимаар болон цаасаар татварын албанд гаргана.

Бүрдүүлэх материал:

Татвар төлөгчөөр бүртгүүлэхэд дараах баримт бичиг шаардлагатай. Үүнд:

1. Татвар төлөгчөөр бүртгүүлэх хүсэлтийн маягт;
2. Гадаад улсын аж ахуйн нэгжийн Монгол улсад төлөөний газраа байгуулах, үйл ажиллагааны чиглэл, ажиллах хугацаа, удирдлагын нэр, ажиллагсдын тоо зэргийг тусгасан шийдвэр;
3. Гадаад улсад татвар төлөгчөөр бүртгүүлснийг нотлох татвар төлөгчийн гэрчилгээ;
4. Толгой компанийн хуулийн этгээдээр бүртгүүлснийг нотлох баримт бичиг /хуулбар/, компанийн дүрэм /хуулбар/;

6. Төлөөний газрын хаяг байршлыг нотлох баримт /түрээсийн гэрээ, г.м/;
7. Төлөөний газрыг удирдах этгээдийг томилсон шийдвэр, итгэмжлэл;
8. Төлөөний газрын удирдлагын анкет, баримт бичгийн хуулбар /удирдлага нь Монгол улсын иргэн бол иргэний үнэмлэхний хуулбар, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газарт бүртгүүлсэн харьяалалгүй хүний түр үнэмлэх, гадаад паспортын хуулбар/;
9. Төлөөний газрын эхлэлтийн санхүүгийн тайлан.

Татварын алба дээр зааснаар бүртгүүлээгүй этгээдийг татварын бүртгэл, мэдээллийн сан болон бусад холбогдох мэдээлэлд үндэслэн татвар төлөгчөөр бүртгүүлэх тухай мэдэгдэл хүргүүлнэ.

Хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх:

Төлөөний газрын үүсгэн байгуулагч, гүйцэтгэх удирдлага, төлөөлөх эрх бүхий албан тушаалтан хүсэлт гаргах эрхтэй байна.

Хүсэлтийг татварын алба хянан шийдвэрлэж, Татварын Бүртгэл Мэдээллийн Нэгдсэн Сан (“ТБМНС”) –д бүртгэлийн мэдээллийг үүсгэн татвар төлөгчийн татварын нэгдсэн мэдээллийн системд нэвтрэх нэр, нууц үгийг бүртгэлтэй гар утас, цахим хаягаар илгээнэ.

ТБМНС –д татвар төлөгчийн бүртгэлийн мэдээллээ баталгаажуулснаар татварын алба ТБМНС-д бүртгэж, татвар төлөгчийн дугаар, цахим гэрчилгээ олгоно.

Төлөөний газрын шаардлага хангасан ч, татвар төлөгчөөр бүртгүүлээгүй бол бүртгэх эрх бүхий байгууллага, ТБМНС-ийн мэдээллийг үндэслэн хуулийн этгээдийн эрхгүй байгууллагад (төлөөний газар) татвар төлөгчөөр бүртгүүлэх мэдэгдэл хүргүүлж болно.

Төлөөний газар нь мэдэгдэл хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор татвар төлөгчөөр бүртгүүлнэ.

Хариуцлага

Төлөөний газраар бүртгүүлэх үүрэг бүхий этгээд төлөөний газраар бүртгүүлээгүй болон өөр бусад хуулийн этгээдийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаа нь татвар төлөх хуулиар хүлээсэн үүрэг хариуцлагаас **чөлөөлөгдөх үндэслэл болохгүй.**

Татвар төлөгч нь төлөөний газраар бүртгүүлээгүй эсвэл төлөөний газрын татвар ногдуулах орлогыг тодорхойлоход шаардагдах нотлох баримтаа татварын албанд гаргаж өгөөгүй тохиолдолд татварын алба төлөөний газрыг бүртгэн Татварын ерөнхий хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу татварын ногдлыг “Жишиг үнийн аргаар тодорхойлох журам”-д заасны дагуу тодорхойлж, **татварыг нөхөн төлүүлнэ.**

ТӨЛӨӨНИЙ ГАЗРЫГ ТАТВАР ТӨЛӨГЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

Татварын алба нь төлөөний газрыг дараах үндэслэлээр татвар төлөгчийн бүртгэлээс хасна:

Уг байгууллагыг байгуулах шийдвэр гаргасан төрийн болон орон нутгийн байгууллага, гишүүдийн татан буулгах тухай шийдвэр.

Дээр заасан нөхцөл үүссэн бол татвар төлөгчийн бүртгэлээс хасуулах тухай хүсэлтээ цахим, эсхүл цаасан хэлбэрээр гаргах бөгөөд татварын алба дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

1. татвар төлөгчийн татварын эрсдэлийг тооцож, эрсдэлтэй тохиолдолд татварын хяналт шалгалтад хамруулах;
2. татварын өр, илүү үлдэгдлийг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;
3. татан буулгах тухай эрх бүхий байгууллага, гишүүдийн шийдвэр, шүүхийн шийдвэр, хяналт шалгалт, эрсдэлийн тооцооллын баримт бичиг, данс хаасан тухай мэдээлэл, санхүүгийн хаалтын тайлан зэрэг мэдээллийг бүрдүүлж хувийн хэрэгт хадгалах;
4. харьяалах татварын албаны бүртгэлийн асуудал хариуцсан нэгж нь “Татвар төлөгчийн хасалтын карт”-ыг хөтлөн, уг шийдвэрийг хянан баталгаажуулж, улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх;
5. татвар төлөгчийн бүртгэлээс хасагдсан тухай татвар төлөгчид мэдэгдэх.

Уг үйл ажиллагааг хэрэгжүүлээгүй, татвар төлөх үүрэг дуусгавар болоогүй тохиолдолд “Татвар төлөгчийн хасалтын карт”-ыг хөтлөхгүй.

Татвар төлөгчийг бүртгэлээс хасахдаа дээрх үйл ажиллагааг бүрэн хэрэгжүүлж, холбогдох баримтыг үндэслэн хасалтыг ТБМНС-д бүртгэнэ.